



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК

Огноо: **2020.08.07**

**ЦАГААН ХАД ДАХЬ ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙН НЭГ ЦЭГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНД АШИГЛАХ ИНТЕРНЕТ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **Цагаан хад дахь гаалийн хяналтын талбайн нэг цэгийн үйлчилгээнд ашиглах интернетийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгох**

Төслийн дугаар: **ЭТТ/202001097**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Цагаан хад дахь гаалийн хяналтын талбайн нэг цэгийн үйлчилгээнд ашиглах интернетийн үйлчилгээ**–г гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх үйлчилгээний зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 09 дүгээр сарын 10-ны 10:00** цагаас өмнө **Төрийн худалдан авах ажиллагааны цахим сайт www.tender.gov.mn** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг **2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 10:30 цаг**-т нээнэ.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв.
(5 давхар, 503 тоот, харилцах албан тушаалтан Х.Батцоож,
7505-5555, дотуур утас: 503)**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч	<p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> <p>1.2. Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- Интернетийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл ирүүлэх /Нотариатаар баталгаажуулсан байх/ <p>1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- Үйлчилгээ үзүүлэгч компани нь өөрсдийн дата төвтэй байх /тоног төхөөрөмжийн үзүүлэлт, жагсаалт, зураг ирүүлэх/- 24 цагийн дуудлагын төвтэй байх. /танилцуулга, дуудлага хүлээн авах утасны дугаар, зураг ирүүлэх/- Орон нутагт төлөөлөгчтэй байх бөгөөд сүлжээ, дэд бүтцэд гэмтэл гарсан тохиолдолд 6 цагаас хэтрэхгүй шийдвэрлэдэг байх.- Сүлжээний байнгын хяналтын системтэй байх. /тухайн хяналтын системийн ДЕМО хувилбар үзүүлэх линкээр, зураг ирүүлэх/- Цахилгааны эх үүсвэр баталгаатай байх, нөөцийн үүсгүүртэй байх. /нотлох бичиг баримт, зураг ирүүлэх/- Интернетийн үйлчилгээ үзүүлэгч компани нь Улаанбаатар хотоос Өмнөговь аймаг Ханбогд сум “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Цагаан хад дахь салбарт интернетийн үйлчилгээ үзүүлэх.- Интернетийн урсгалыг ринг буюу backup холболтыг хийх тухай албан бичиг ирүүлэх
2. Тендерийн иж бүрдэл	<p>2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none">(a) <i>Үнийн санал;</i>(б) <i>Үйл ажиллагааны хуваарь;</i>(в) <i>Улсын бүртгэлийн гэрчилгээг эх хувиас хуулбарлаж ирүүлэх;</i>(г) <i>Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.</i>(д) <i>Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлэх /Тендер нээх өдрөөр хүчинтэй байх/</i>(е) <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт /Тендер нээх өдрөөр хүчинтэй байх/</i>

	<p>(ё) <i>Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт ирүүлэх /Тендер нээх өдрөөр хүчинтэй байх/</i></p> <p>(ж) <i>Гэрээг хэрэгжүүлэхэд санал болгож буй баг нь 3 ба түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл, дипломын хуулбар, НД-7, НД-8 маягтыг сүүлийн 6 сараар ирүүлэх</i></p> <p>(з) <i>Харилцагч банк, нийгмийн даатгал, татварын газар болон шүүхийн байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх</i></p> <p>(и) <i>Сүүлийн 2 (2018, 2019 он) жилийн нийт борлуулалтын орлого нь төсөвт өртгөөс багагүй байна.</i></p> <p>(к) <i>Техникийн тодорхойлолтод заасан нөхцөл шаардлагуудыг бүрэн хангасан байх</i></p> <p>2.2. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> <p>(a) [1. Үнийн саналын маягт]</p> <p>(б) [Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор бүх баримт бичгийг жагсаан бичих]</p> <p>(в)</p>
<p>3. Тендерийн үнэ</p>	<p>3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.</p> <p>3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.</p> <p>3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон үйл ажиллагааны хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.</p> <p>3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.</p>

4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Алдааг залруулах	<p>5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:</p> <p>(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;</p> <p>(б) үйл ажиллагааны үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;</p> <p>(в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.</p> <p>5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.</p>
6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	<p>6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p>
7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан үйлчилгээг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр үйлчилгээ дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч үйлчилгээг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан үйл ажиллагааны хуваарь болон төслийн менежерийн баталсан тодотгосон үйл ажиллагааны хуваарийн дагуу хийж гүйцэтгэн, үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.
4.2. Үйлчилгээ үзүүлэхэд байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь үйлчилгээтэй холбогдуулж байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй. |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

7. Үйл ажиллагааны хуваарь

7.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хуваарийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Үйл ажиллагааны хуваарийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь үйл ажиллагааны хуваарийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.

8. Зөрчил, гологдол илрүүлэх

8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн үзүүлсэн үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа үйчилгээнд зөрчил, гологдол хайх, далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

9. Зөрчил, гологдол арилгах

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

10. Зөрчил, гологдол арилгахгүй байх

10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хуулийг баримтална.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үйл ажиллагааны хуваарь

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарийн тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үйл ажиллагааны хуваарь нь үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үйл ажиллагааны хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

12. Үйл ажиллагааны хуваарийг өөрчлөх

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр үйлчилгээний арга барил, эсхүл үйл ажиллагааны хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үйл ажиллагааны хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Үйлчилгээ дуусгах

14.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер үйлчилгээ дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.

15. Хүлээж авах

15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

16. Эцсийн тооцоо

16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн

² Алдангийг ихэвчлэн хоногт 0,05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Гэрээг цуцлах

17.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

17.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

(а) Үйл ажиллагааны хөтөлбөрт үйлчилгээ зогсоох тухай заагаагүй, түүнчлэн үйлчилгээ зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч үйлчилгээг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер үйлчилгээний явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;

(д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(е) гүйцэтгэгч үйлчилгээний гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

17.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч үйлчилгээг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд

чөлөөлнө.

**18. Гэрээг
цуцалсан үед хийх
төлбөр**

18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн үйлчилгээний болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй үйлчилгээний гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.

18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн үйлчилгээ болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, үйлчилгээний зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**19. Гүйцэтгэлээс
чөлөөлөх**

19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйлчилгээг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн үйлчилгээ болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн үйлчилгээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

2.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: **Цагаан хад дахь гаалийн нэг цэгийн үйлчилгээнд ашиглах интернетийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгох, ЭТТ/202001097**

2.1 Ажил нь: *Гаалийн хяналтын талбайн нэг цэгийн үйлчилгээний оффисыг шилэн кабелиар эсвэл антениар интернэт холбож, дотоод сүлжээ /Lan/ үүсгэж өөрсдийн тоног төхөөрөмж суурилуулж интернет болон vpn холболт хийж ЭТТ-д хүлээлгэн өгөх-өөс бүрдэнэ.*

Ажлын талбай нь: *Өмнөговь аймаг, Ханбогд сум, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Цагаан хад захь салбар-д*

3.1 Төслийн менежер нь: *Гэрээнд тусгайлан заана*

4.1 Ажил эхлэх өдөр: *Гэрээ байгуулагдсан өдрөөс*

Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: *Гэрээний хугацаа нэг жил байна. Тоног төхөөрөмж суурилуулж, интернет болон vpn холболт хийх ажлыг 14 хоногт багтаан гүйцэтгэнэ.*

Төлбөрийг дараах хуваарийн дагуу хийнэ:

- *Урьдчилгаа төлбөр: Урьдчилгаа төлбөр байхгүй*
- *Ажлын үр дүнгийн үзүүлэлтэд үндэслэн үйлчилгээ үзүүлэгчийн шаардлагад нийцсэн сар бүрийн гүйцэтгэлийг захиалагч хүлээн зөвшөөрч баталгаажуулсны үндсэн дээр нэхэмжлэх болон бусад холбогдох баримтыг үндэслэн төлбөрийг хуанлийн 30 хоногт багтаан шилжүүлнэ.*

13.1 Алданги ногдуулах хэмжээ нь: *Хоногт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь* байна.⁴

Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь: *Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувь* байна.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ИНТЕРНЭТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Өмнөговь аймаг Ханбогд сум Цагаанхад дахь “Эрдэнэс-Тавантолгойн” ХК-ийн Гаалийн хяналтын талбайн нэг цэгийн үйлчилгээний оффист интернет болон vpn сүлжээ үүсгэх, сайжруулах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал болон сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангасан интернетийн үйлчилгээ үзүүлэгч компани сонгон шалгаруулах.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь Цагаанхад дахь оффист dedicated интернетийн урсгал авна. Төв оффисоос уурхай хооронд vpn сүлжээ үүсгэж холбоно. Үйлчилгээ үзүүлэгч компани нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Цагаанхад дахь Гаалийн хяналтын талбайн нэг цэгийн үйлчилгээний оффисыг шилэн кабелиар эсвэл антениар интернэт холбож, дотоод сүлжээ /Lan/ үүсгэж өөрсдийн тоног төхөөрөмж суурилуулж интернет болон vpn холболт хийж ЭТТ-д хүлээлгэн өгнө. /Интернэт, дотоод сүлжээ үүсгэх шийдэл, төлөвлөгөө ирүүлэх/

Интернэт, vpn холболт хийх хурд болон байршил /dedicated line/			
1.	Эрдэнэс таван толгой ХК-ийн Өмнөговь аймаг, Ханбогд сум, Цагаанхад дахь оффис	Internet Шилэн кабель эсвэл сүлжээний антень	10 mbps түүнээс дээш
2.	Улаанбаатар дахь төв оффисоос Өмнөговь аймаг Цогт цэций сум, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Уурхай, Цагаанхад дахь боомт хооронд	VPN	10 mbps түүнээс дээш

• Тавигдах шаардлага

1.	Үйлчилгээ үзүүлэгч компани нь өөрсдийн тоног төхөөрөмж суурилуулж интернэт болон vpn холболт хийж “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д хүлээлгэн өгнө.
2.	Дараах координатын дагуу ажлыг гүйцэтгэнэ – 42.590892, 107.518187
3.	Интернетийн үйлчилгээ үзүүлэгч компанийн цамхагаас “Эрдэнэс-Тавантолгой” ХК Гаалийн хяналтын талбайн нэг цэгийн үйлчилгээний оффис хүртэл антен байршуулахаар бол байршуулах антенны марк дугаар танилцуулга ирүүлэх
4.	Төгсгөлийн төхөөрөмж нь нэмэлт тохиргоо rule бичих нэмэлт боломжтой байх <ul style="list-style-type: none">• Routing хийх төхөөрөмж дээр хэрэглэгчийн MAC хаягийг бүртгэх• WIFI radius server тохируулах, цагийн хязгаарлалт хийх гэх мэт

5.	Firewall-н Стандарт портуудыг нээж, шаардлагагүй портуудыг хаах, content filter хийх гэх мэт тохиргоо хийх.
6.	Дотоод интернетийн урсгалд хурдны хязгаар тавихгүй байх.
7.	Интернет болон VPN сүлжээний үйлчилгээ үзүүлэгч компани нь нөөц гадаад, дотоод интернетийн гарцтай байх. /холболтын зураг ирүүлэх/
8.	Интернет болон VPN сүлжээний үндсэн холболт нь нууцлал /encryption/ хийсэн байх.
9.	Интернетийн үйлчилгээ үзүүлэгч компани нь холболт хийх тоног төхөөрөмжийн жагсаалт ирүүлэх. /холболтын зураг ирүүлэх/
10.	Интернет болон VPN гарц дээр Network traffic monitoring хийх програм хангамж суулгасан байх.
11.	Интернетийн үйлчилгээ үзүүлэгч компани нь өөрсдийн тоног төхөөрөмж дээр засвар үйлчилгээ хийх үед мэдээллийн технологийн мэргэжилтэнд урьдчилан мэдэгдэж байх.
12.	Интернетийн үйлчилгээ үзүүлэгч компанийн мэдээллээ ирүүлэх <ul style="list-style-type: none"> • Үйлчилгээ үзүүлэгч компани нь дата төвтэй байх • 24 цагийн дуудлагын төвтэй байх. /танилцуулга, дуудлага хүлээн авах утасны дугаар, зураг ирүүлэх/ • Сүлжээний байнгын хяналтын системтэй байх. /тухайн хяналтын системийн ДЕМО хувилбар үзүүлэх линкээр, зураг ирүүлэх/ • Цахилгааны эх үүсвэр баталгаатай байх, нөөцийн үүсгүүртэй байх. /нотлох бичиг баримт, зураг ирүүлэх/
13.	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Гаалийн хяналтын талбайн нэг цэгийн үйлчилгээний оффист гарсан сүлжээний гэмтэл, доголдлыг ажлын 8 цагт багтан түргэн шуурхай ирж засварлах инженертэй /төлөөлөгчтэй/ байх.
14.	Интернетийн үйлчилгээ үзүүлэгч компани нь Өмнөговь аймаг, Ханбогд сум, Цагаанхад дахь Гаалийн хяналтын талбайн нэг цэгийн үйлчилгээний оффист сүлжээний тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан нөөцтэй байх. /жагсаалтаар ирүүлэх/
15.	Интернетийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл ирүүлэх.

Зургаа. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Долоо. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ⁵

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нэгж, эсхүл нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг

⁵ Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино. (Энэ бүлэгт нийтэд нь)

магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн), хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Найм. Жишиг маягт

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг,

тамга: _____

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “ажил” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс :
Улсын төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Орон нутгийн төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Өөрийн хөрөнгө: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт;

Зураг;

Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь⁶;

Санхүүжилтийн хуваарь;

Ажил гүйцэтгэх хуваарь;

Бусад шаардлагатай баримт бичиг⁷.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

2. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

3. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

4. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

5. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

⁶ Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино.

⁷ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
*үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
*үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]